

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын Илдэн бүрэн ААТҮГ-ын
2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/19-СТА-ОНА

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn
Сүхбаатар сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Аудитор: Д.Чулуунцэцэг
Утас: 70363036 Цахим хаяг: chuluuntsetseg.d@audit.local

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт.....	3
1.Аудитын санал дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	7
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	7
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	7
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	8
4. Аудитын тайлан	9
4.4 Материаллаг байдал.....	10
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	10
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	11
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
8. Аудитын илрүүлэлт.....	12
8.1 Албан шаардлага.....	12
8.2 Зөвлөмж	13
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СЭА	Сэлэнгэ аймаг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ГЗҮҮНБҮРЭН СУМЫН “ИЛДЭН БҮРЭН”
ААТҮГ-ЫН ДАРГА Ц. БАТМӨНХ ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.15 № СЭА-2022/19-НА-ӨД-ОНА
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Илдэн бүрэн” ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол “Илдэн бүрэн” ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Тухайн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдтэй орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор байгуулсан “Нийгмийн хариуцлагын гэрээ”-ний дагуу **49,794.3** мянган төгрөгийн хандивын орлогыг сумын ОНХС-ийн дансанд бус тус ААТҮГ-ын дансанд төвлөрүүлж зарцуулсан.
- ААТҮГ-ын 2021 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтнаар батлуулаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь “Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:” 60.2.5: “Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, ...”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж,

СЭА-2022/19-НА-СТА-ОНА

018020391

зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Бусад мэдээлэл

Тайлант онд үйлдвэрийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдаагүй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		4,221,904.16
1.1.6	Бараа материал		38,323,100.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн		42,545,004.16
1.3	Нийт хөрөнгийн дүн		42,545,004.16
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3	Өмч		38,323,100.00
2.3.1	-төрийн		38,323,100.00
2.3.2	-хувийн		
2.3.9	Хуримтлагдсан ашиг		4,221,904.16
2.3.11	Эздийн өмчийн дүн		4,221,904.16
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		42,545,004.16

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)		
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)		
8	Бусад орлого		49,794,304.16
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал		7,249,300.00
12	Бусад зардал		38,323,100.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		4,221,904.16
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараахь ашиг (алдагдал)		4,221,904.16
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		4,221,904.16
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	Орлогын нийт дүн		4,221,904.16

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

				/төгрөгөөр/
№	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл			0.0
2	Залруулсан үлдэгдэл			0.0
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			0.0
4	2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл			0.0
5	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		4,221,904.16	4,221,904.16
6	Өмчид гарсан өөрчлөлт	38,323,100.00		38,323,100.00
7	2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	38,323,100.00	4,221,904.16	42,545,004.16

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/төгрөгөөр/
№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн		49,794,304.16
1.1.6	Бусад мөнгөн орлого		49,794,304.16
1.2	Мөнгөн зарлагын дүн		45,572,400.0
1.2.1	Ажиллагчдад төлсөн		1,532,900.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		1,297,400.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн		38,323,100.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		1,456,500.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага		2,962,500.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		4,221,904.16
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		4,221,904.16
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ		
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ		4,221,904.16

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Зүүнбүрэн сумын “Илдэн бүрэн” ААТҮГ нь “Орон нутгийн өмчийн өөрийн санхүүгийн тайланд бүртгэгдсэн эд, хөрөнгө, дүрмээр хүлээсэн эрх, үүргийн хүрээнд улс, орон нутгийн төсвөөс олгогдсон хөрөнгө оруулалтаар болон бусад үйл ажиллагааны орлогоор санхүүжих замаар бие даан үйл ажиллагаа явуулж, орон нутгийн өмчит нийтийн эзэмшлийн зам талбай, тохижилт, ногоон байгууламж, гэрэлтүүлэг, хог хаягдлын тээвэрлэлт, төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагаа эрхлэх” гэсэн эрхэм зорилготойгоор байгуулагдсан байна.

“Илдэн бүрэн” ААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааг үйл ажиллагааны төсөв, техникийн хүчин чадлыг харгалзан дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын төвийн нийтийн эзэмшлийн талбайн, авто зам төвлөрсөн цэгийн хог хаягдлыг цэвэрлэх, ачих тээвэрлэх,
- Сумын төвийн нийтийн эзэмшлийн талбайн тохижилт үйлчилгээ,
- Гудамжны гэрэлтүүлгийн ашиглалт засвар үйлчилгээ,
- Гадаад болон дотоодод худалдаа эрхлэх,
- Нийтийн халуун усны үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах,
- Сумын халаалтын зуухны үйл ажиллагааг эрхлэх, иргэн аж ахуйн нэгж, байгууллагыг дулаанаар хангах.
- Авто тээвэр, бусад төрлийн машин механизмаар төлбөртэй үйлчлэх,
- Өөрийн эзэмшлийн хөрөнгө болон ажил үйлчилгээг бусдад түрээсээр ашиглуулах гэх мэт

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Илдэн бүрэн” ААТҮГ -ыг сумын ИТХТ-ийн 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 26 дугаар тогтоолоор байгуулсан байна. Энэ нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлд “Сум, дүүргийн Хурлын бүрэн эрх” 18 дугаар зүйлийн 18.1.3 ж-д “ Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ **орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих**” гэж заасантай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1,0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- Сумын ИТХТ-ийн 2021 оны 26 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Илдэн бүрэн” ААТҮГ-ын дүрэм гэх мэт.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Илдэн бүрэн” ААТҮГ-ын санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
			/мянган төгрөг/
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	4,221.9	-
Бараа материал	-	38,323.1	-
Үндсэн хөрөнгө	-	-	-
Нийт хөрөнгө	-	42,545.0	-
Өр төлбөр	-	-	-
Хуримтлагдсан ашиг/+/ , алдагдал/-/	-	4,221.9	-
Өмч-Төрийн	-	38,323.1	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	-	42,545.0	-

Банкин дахь харилцах дансны үлдэгдэл 4,221.9 мянган төгрөг нь нийгмийн хариуцлагын хүрээнд суманд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдээс төвлөрсөн хандивын орлогын зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

Бараа материалын данс 38,323.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь тайлант онд 27,000.0 мянган төгрөгийн цэцэрлэгт хүрээлэнгийн 2 га талбайн хашаа, 8,980.8 мянган төгрөгийн засмал зам дагуух ногоон байгууламжийн хашаа, 1,011.5 мянган төгрөгийн дээврийн төмөр банз, усалгааны цахилгааны утас, 1,330.8 мянган төгрөгийн цэцэрлэгт хүрээлэнгийн самбар зэргийг хийх материалуудыг худалдан авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайланд Одон буудай, Газар өгөөж, Халиун Уул, Гэгээлэг, Энх хос мөрөн, Арвин хур, Шижир болор, Гацуурт, Ургац агро,

Газар агро, Бүрэн тал, Санчир буудай, Алтантариа зэрэг ХХК-тай байгуулсан “Нийгмийн хариуцлагын гэрээ”-нд эзэмшиж буй нийт тариалангийн талбайн 1 га тутамд 3500 төгрөгөөр тооцож жилд нэг удаа орлого төвлөрүүлэхээр заасны дагуу 49,794.3 мянган төгрөгийн хандивын орлогыг төвлөрүүлж, бусад орлогоор бүртгэж тайлагнасан байна.

Төвлөрсөн орлогоос ахмад настан, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх таатай орчныг бүрдүүлэх зорилгоор сумын төвд цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажилд зарцуулсан 38,323.1 мянган төгрөгийн зардлыг бусад зардлаар, байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан цалин, болон бусад зардлын 7,249.3 мянган төгрөгийг ерөнхий удирдлагын зардлаар тайлагнасан байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Илдэн бүрэн” ААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Илдэн бүрэн” ААТҮГ-ын дарга нь 2021 оны байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтнаар батлуулаагүй байна.

Гүйцэтгэлээр ИТХТ-ийн 2021 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан үйл ажиллагааны чиглэлийн дагуу ажил үйлчилгээ эрхлээгүй боловч тухайн байгууллагын ХААН банкин дахь дансанд 49,794.3 мянган төгрөгийн бусад орлого төвлөрч 45,572.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, үүнээс ерөнхий удирдлагын зардалд 7,249.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Илдэн бүрэн аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар /цаашид Илдэн бүрэн ААТҮГ гэх/-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Чулуунцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Илдэн бүрэн ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт сумын Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 1/39 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Тайлант жилийн хугацаанд хяналт, шалгалт хийгээгүй байна.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Илдэн бүрэн ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 49,794.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 995.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн болно.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Илдэн бүрэн ААТҮГ нь 2021 оны 3 дугаар сараас биеэ даан үйл ажиллагаа явуулахаар байгуулагдсан боловч шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд цахим хаяг нээлгээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна. **3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд**; 7.1. "шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ", 7.1.3 "тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим санд хаяг нээлгэж, холбогдох мэдээллийг мэдээлж байх албан шаардлага хүргүүлэх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын 1.3-д "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх" гэж заасны дагуу шагнал урамшуулал олгоогүй, зочин төлөөлөгч хүлээн авах болон бэлэг дурсгалын зардал гаргаагүй байна.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант онд шинээр үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаа явуулсан тул өмнөх оны мэдээлэл байхгүй болно.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

7.1 Илдэн бүрэн ААТҮГ нь сумын ИТХТ-ийн 2021 оны 26 дугаар тогтоолоор байгуулагдсан боловч батлагдсан үйл ажиллагааны чиглэлийн дагуу ажил үйлчилгээ эрхлээгүй бөгөөд Төсвийн тухай хуулийн дагуу сумын ОНХС-д төвлөрүүлбэл зохих газар тариалангийн аж ахуйн нэгжүүдийн хандивын орлогыг үйлдвэрийн газрын дансанд төвлөрүүлж, үйл ажиллагаа явуулсан байна.

Цаашид шаардлагатай гэж үзвэл уг ААТҮГ-ын орлогын эх үүсвэрийг тодорхойлж, дүрмэнд заасан үйл ажиллагааг эрхлэх, орлого эх үүсвэр тодорхойгүй нөхцөлд үйлдвэрийн газрыг татан буулгах нь зүйтэй юм.

7.2 Хөрөнгө мөнгийг захиран зарцуулах, нягтлан бодох бүртгэл хөтлөх чиг үүрэг бүхий нягтлан бодогчийг албан ёсоор томилоогүй, жилийн эцсийн байдлаар нягтлан бодогчгүй үйл ажиллагаа явуулж байгаа нь хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг алдагдуулж байна. Цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулна гэж үзвэл албан ёсны нягтлан бодогчийг томилж ажиллуулах нь зүйтэй юм.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 88,117.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 49,794.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 38,323.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөгдлөө.

8.1 Албан шаардлага

1. Тухайн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдтэй орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор байгуулсан “Нийгмийн хариуцлагын гэрээ”-ний дагуу төвлөрсөн 49,794.3 мянган төгрөгийн орлогыг ААТҮГ-ын дансанд төвлөрүүлж зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь “Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:” 60.2.5: “Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж,” гэсэн заалттай нийцээгүй ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн хариуцлагын хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагаас төвлөрүүлсэн хандивын хөрөнгийг тус үйлдвэрийн газрын дансанд төвлөрүүлж буй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх.

2. ААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтнаар батлуулаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулан холбогдох албан тушаалтнаар батлуулж, мөрдөх албан шаардлага хүргүүлэх.

8.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.1. Илрүүлэлт: Тайлант онд худалдан авсан 38,323.1 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдээр баталгаажсан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ", Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, санхүү нягтлан бодох бүртгэлийн программтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Аймгийн ТЕЗ буюу Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж, ажиллаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ..., мөрдөж ажиллана." гэж заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс					
						Залруулга		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар											
1	"Илдэн бүрэн" ААТҮГ	СЭА-2022/19-НА-СТА-ОНА	Тухайн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдтэй орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор байгуулсан "Нийгмийн хариуцлагын гэрээ"-ний дагуу төвлөрсөн орлогыг ААТҮГ-ын дансанд төвлөрүүлж зарцуулсан байна.	1	49,794.3	-	-	1	49,794.3	-	-
2	"Илдэн бүрэн" ААТҮГ	СЭА-2022/19-НА-СТА-ОНА	ААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтнаар батлуулаагүй байна	1				1			-
3	"Илдэн бүрэн" ААТҮГ	СЭА-2022/19-НА-СТА-ОНА	Аймгийн ТЕЗ буюу Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж, ажиллаагүй байна.	1						1	-
4	"Илдэн бүрэн" ААТҮГ	СЭА-2022/19-НА-СТА-ОНА	Тайлант онд худалдан авсан бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдээр баталгаажсан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.	1	38,323.10					1	38,323.10
ДҮН				4	88,117.40			2	49,794.3	2	38,323.10
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал											
1	"Илдэн бүрэн" ААТҮГ	СЭА-2022/19-НА-СТА-ОНА	Шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд цахим хаяг нээлгээгүй байна.	1				1			
ДҮН				1	-			1	-		
НИЙТ ДҮН				5	88,117.40			3	49,794.3	2	38,323.10



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

᠒᠐᠒᠒ оны ᠐3 сарын 15 өдөр

Дугаар 12᠐/᠕᠐5᠐385
СӨА-᠒᠐᠒᠒/1᠑-НА-СТА-ОНА

Сүхбаатар

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Илдэн бүрэн" ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Тухайн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдтэй орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор байгуулсан "Нийгмийн хариуцлагын гэрээ"-ний дагуу 49,794.3 мянган төгрөгийн хандивын орлогыг ОНХС-ийн дансанд бус тус ААТҮГ-ын дансанд төвлөрүүлж зарцуулсан.
- ААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтнаар батлуулаагүй.
- Шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд цахим хаяг нээлгээгүй байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь "Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:" 60.2.5: "Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, ...", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна. 3.1.1: Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд" 7.1. "Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ", 7.1.3 :Тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана"

018040362

,4.2.1.11 “Хууль тогтоомж,... зөрчсөн...” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Дээрх зөрчлүүдийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг “Илдэн бүрэн” ААТҮГ-ын дарга Ц.Батмөнх-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

АУДИТОР

Д.ЧУЛУУНЦЭЦЭГ

